

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/088/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2025 он	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	18-18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	22-23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ЗДҮАХХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ХОЙД БҮС ДЭХ ГАЗРЫН ДАРГА
Б. МӨНХБАТ ТАНАА

2025.02.14 № СА-2025/088/МА-СА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурав сар ажилласанд тооцох, хилийн боомт, орон нутаг дахь албанд таваас доошгүй жил ажиллаж байгаа албан хаагчид ажилласан таван жил тутам 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж, тайлант онд 1 албан хаагчид 38,385.7 мянган төгрөгийг тооцож олгосон байна.

432502015

Аудитын гол асуудал

ХЗДХС-аас аймгийн Засаг даргатай 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний 1 дүгээр хавсралтаар баталсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 онд ХЗДХС-ийн эрхлэх асуудлын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний 6.1 дэх “Хойд бүс дэх газраас аймгийн төрийн санд төвлөрүүлсэн орлогын **30 хувийг хойд бүс дэх газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад зарцуулах**” гэсэн заалтын дагуу тайлант онд аймгийн төсвөөс 137,462.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар нь “Хүний эрх, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт хүрсэн нээлттэй, хариуцлагатай төрийн үйлчилгээг явуулах” зорилго дэвшүүлж, 3 зорилт, 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	117,339,302.10	104,420,251.91
35	БАРАА МАТЕРИАЛ	117,339,302.10	104,420,251.91
35100	Түүхий эд материал	3,982,519.00	3,713,519.00
35130	Эм боох материал	3,982,519.00	3,713,519.00
35400	Хангамжийн материал	113,356,783.10	100,706,732.91
35410	Бичиг хэргийн материал	2,443,425.00	2,407,200.00
35420	Аж ахуйн материал	6,074,450.00	5,379,451.00
35430	Сэлбэг хэрэгсэл	19,806,500.00	8,294,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,982,500.00	8,994,302.00
35450	Барилгын засварын материал	5,064,500.00	556,000.00
35470	Бусад хангамжийн материал	76,985,408.10	75,075,779.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	458,874,839.89	562,857,913.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	458,874,839.89	562,857,913.14
39200	Биет хөрөнгө	214,171,589.89	317,295,913.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	63,264,054.11	63,264,054.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,135,493.98)	(27,856,645.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245,500,000.00	224,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(115,673,611.20)	(112,763,888.85)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	85,557,496.43	122,813,998.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(59,189,339.92)	(48,431,643.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,455,219.99	108,387,169.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,606,735.54)	(12,117,132.22)
39300	Биет бус хөрөнгө	244,703,250.00	245,562,000.00
39301	Програм хангамж	1,980,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,938,750.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	244,662,000.00	244,662,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	576,214,141.99	667,278,165.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	576,214,141.99	667,278,165.05
51	Засгийн газрын хувь оролцоо	576,214,141.99	667,278,165.05
51100	Засгийн газрын оруулсан капитал	244,662,000.00	244,662,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	244,662,000.00	244,662,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	326,768,003.35	417,832,026.41
51210	Өмнөх үеийн үр дүн	357,706,127.54	326,775,549.46
51220	Тайлант үеийн үр дүн	(30,938,124.19)	91,056,476.95
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,784,138.64	4,784,138.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	576,214,141.99	667,278,165.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	995,647,140.20	1,517,880,859.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,900,540.20	165,237,622.81
120	Нийтлэг татварын бус орлого	21,900,540.20	165,237,622.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	136,260,352.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	136,260,352.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	18,204,106.31
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,900,540.20	10,773,164.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	973,746,600.00	1,352,643,237.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	973,746,600.00	1,313,336,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	973,746,600.00	1,313,336,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	39,306,437.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	39,306,437.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,017,122,500.89	1,425,883,070.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,017,122,500.89	1,425,883,070.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	770,482,399.91	1,179,348,585.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,989,898.77	843,228,574.41
210101	Үндсэн цалин	341,415,952.81	427,659,933.87
210102	Нэмэгдэл	125,889,945.35	219,861,363.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,919,684.84	150,433,667.29
210104	Урамшуулал	29,764,315.77	45,273,609.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,376,014.99	109,937,825.86
210201	Тэтгэврийн даатгал	46,865,814.99	74,172,981.16
210202	Тэтгэмжийн даатгал	7,126,900.00	9,231,152.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,702,200.00	4,705,544.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,425,700.00	4,705,644.27
210205	Эрүүл мэндийн даатгал	14,255,400.00	17,122,504.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,640,827.26	12,312,079.06
210301	Гэрэл, цахилгаан	454,866.00	33,544.67
210302	Түлш, халаалт	1,656,272.37	2,186,290.73
210303	Цэвэр, бохир ус	746,008.89	2,624,243.66
210304	Байрны түрээс	8,783,680.00	7,468,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,807,200.00	41,056,067.47
210401	Бичиг хэрэг	2,837,650.00	6,172,775.00
210402	Тээвэр, шатахуун	11,729,500.00	25,920,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,237,500.00	2,437,543.47
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,002,550.00	6,524,899.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,377,692.00	75,117,137.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,322,692.00	253,000.00
210604	Урсгал засвар	55,000.00	74,864,137.00
2107	Томилолт, зочны зардал	1,594,000.00	3,122,000.00
210702	Дотоод албан томилолт	1,594,000.00	3,122,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,037,618.00	21,821,123.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,991,180.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,975.00	348,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211,243.00	325,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	9,122,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,889,400.00	6,945,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,659,148.89	72,753,779.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,243,240.00	4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,760,800.00	3,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,655,108.89	65,453,779.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,640,100.98	246,534,484.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,978,571.00	41,445,708.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,300,000.00	3,060,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	115,678,571.00	38,385,708.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	128,661,529.98	205,088,776.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	128,661,529.98	205,088,776.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(21,475,360.69)	91,997,789.64
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,462,763.50	941,312.69
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	9,462,763.50	941,312.69
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(30,938,124.19)	91,056,476.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	973,746,600.00	1,352,643,237.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	973,746,600.00	1,352,643,237.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	973,746,600.00	1,313,336,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	973,746,600.00	1,313,336,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	39,306,437.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	39,306,437.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	970,776,600.00	1,337,545,737.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	970,776,600.00	1,337,545,737.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,136,499.02	1,091,011,252.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	591,989,898.77	843,228,574.41
210101	Үндсэн цалин	341,415,952.81	427,659,933.87
210102	Нэмэгдэл	125,889,945.35	219,861,363.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,919,684.84	150,433,667.29
210104	Урамшуулал	29,764,315.77	45,273,609.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,376,014.99	109,937,825.86
210201	Тэтгэврийн даатгал	46,865,814.99	74,172,981.16
210202	Тэтгэмжийн даатгал	7,126,900.00	9,231,152.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,702,200.00	4,705,544.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,425,700.00	4,705,644.27
210205	Эрүүл мэндийн даатгал	14,255,400.00	17,122,504.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,640,827.26	12,512,079.06
210301	Гэрэл, цахилгаан	454,866.00	33,544.67
210302	Түлш, халаалт	4,656,272.37	2,386,290.73
210303	Цэвэр, бохир ус	746,008.89	2,624,243.66
210304	Байрны түрээс	8,783,680.00	7,468,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,827,300.00	44,237,543.47
210401	Бичиг хэрэг	3,104,000.00	6,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,056,500.00	29,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,237,500.00	2,437,543.47
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,429,300.00	6,000,000.00
2105	Нормативт зардал	-	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	59,365,607.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	448,470.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	58,917,137.00
2107	Томилолт, зочны зардал	1,594,000.00	3,122,000.00
210702	Дотоод албан томилолт	1,594,000.00	3,122,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,148,218.00	11,007,623.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,991,180.00
210803	Даатгалын үйлчилгээ	348,975.00	348,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	211,243.00	325,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,500,000.00	5,122,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	132,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,060,240.00	7,300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,668,240.00	4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,392,000.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,640,100.98	246,534,484.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,978,571.00	41,445,708.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,300,000.00	3,060,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	115,678,571.00	38,385,708.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	128,661,529.98	205,088,776.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	128,661,529.98	205,088,776.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,970,000.00	15,097,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,970,000.00	15,097,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,970,000.00	15,097,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,970,000.00	15,097,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,970,000.00	15,097,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,970,000.00)	(15,097,500.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	357,706,127.54	607,152,266.18
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	357,706,127.54	607,152,266.18
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(30,938,124.19)	(30,938,124.19)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	326,768,003.35	576,214,141.99
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	326,768,003.35	576,214,141.99
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,546.11	7,546.11
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	326,775,549.46	576,221,688.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	91,056,476.95	91,056,476.95
20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	244,662,000.00	4,784,138.64	417,832,026.41	667,278,165.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,313,336,800.00	1,108,248,023.80	205,088,776.20	84.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,313,336,800.00	1,108,248,023.80	205,088,776.20	84.38
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,270,076,800.00	1,066,802,315.80	203,274,484.20	84.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,010,347,900.00	843,228,574.41	167,119,325.59	83.46
210101	Үндсэн цалин	451,404,400.00	427,659,933.87	23,744,466.13	94.74
210102	Нэмэгдэл	255,479,500.00	219,861,363.86	35,618,136.14	86.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	212,078,000.00	150,433,667.29	61,644,332.71	70.93
210104	Урамшуулал	91,386,000.00	45,273,609.39	46,112,390.61	49.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,281,000.00	109,937,825.86	29,343,174.14	78.93
210201	Тэтгэврийн даатгал	94,711,000.00	74,172,981.16	20,538,018.84	78.32
210202	Тэтгэмжийн даатгал	11,142,500.00	9,231,152.06	1,911,347.94	82.85
210203	ҮОМШ-ний даатгал	5,571,200.00	4,705,544.27	865,655.73	84.46
210204	Ажилгүйдлийн даатгал	5,571,300.00	4,705,644.27	865,655.73	84.46
210205	Эрүүл мэндийн даатгал	22,285,000.00	17,122,504.10	5,162,495.90	76.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,388,600.00	12,512,079.06	4,876,520.94	71.96
210301	Гэрэл, цахилгаан	1,737,900.00	33,544.67	1,704,355.33	1.93
210302	Түлш, халаалт	2,500,000.00	2,386,290.73	113,709.27	95.45
210303	Цэвэр, бохир ус	5,089,900.00	2,624,243.66	2,465,656.34	51.56
210304	Байрны түрээс	8,060,800.00	7,468,000.00	592,800.00	92.65
2104	Хангамж, бараа материалын зардал	45,490,000.00	44,237,543.47	1,252,456.53	97.25
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	29,800,000.00	29,800,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэт	3,690,000.00	2,437,543.47	1,252,456.53	66.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	-	-	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	300,000.00	300,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,218,000.00	35,156,670.00	61,330.00	99.83
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,100,000.00	15,097,500.00	2,500.00	99.98
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	448,470.00	51,530.00	89.69
210604	Урсгал засвар	19,618,000.00	19,610,700.00	7,300.00	99.96
2107	Томилолт, зочны зардал	3,122,000.00	3,122,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	3,122,000.00	3,122,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,629,300.00	11,007,623.00	621,677.00	94.65

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00	4,991,180.00	8,820.00	99.82
210803	Даатгалын Үйлчилгээ	400,000.00	348,975.00	51,025.00	87.24
210804	Тээврийн хэрэгслийн татвар	411,300.00	325,468.00	85,832.00	79.13
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	-	100.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	5,130,000.00	5,122,000.00	8,000.00	99.84
210807	Газрын төлбөр	300,000.00	-	300,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300,000.00	132,000.00	168,000.00	44.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,300,000.00	7,300,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	4,300,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,260,000.00	41,445,708.00	1,814,292.00	95.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,260,000.00	41,445,708.00	1,814,292.00	95.81
213204	Бусад Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,060,000.00	3,060,000.00	-	100.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,200,000.00	38,385,708.00	1,814,292.00	95.49
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,313,336,800.00	1,313,336,800.00	-	100.00
31	Улсын төсвөөс санхүүжих	1,313,336,800.00	1,313,336,800.00	-	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,313,336,800.00	1,313,336,800.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		39,306,437.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		39,306,437.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		39,306,437.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		39,306,437.00
210604	Урсгал засвар		39,306,437.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		39,306,437.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		39,306,437.00
131103	ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс		39,306,437.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газар /цаашид ГИХГ-ын Хойд бүс дэх газар гэх/ нь “Хүний эрх, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт хүрсэн нээлттэй, хариуцлагатай төрийн үйлчилгээг явуулах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- Монгол улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдэд тавих хяналтыг хэрэгжүүлэх,
- Иргэний харьяалал, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.


Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ГИХГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд 2024 оны 1-3 дугаар улирлын үйл ажиллагааг хамруулан дотоод аудит, хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын дүнг үндэслэн ГИХГ-ын даргын 2024 оны 03 дугаар “Ажлын хариуцлагыг сайжруулах тухай” албан даалгавраар санхүүгийн үйл

ажиллагааны чиглэлээр 8 үүргийн хэрэгжилтийг хангаж, тооцож ажиллахыг даалгасны дагуу биелэлтийг гаргаж, хүргүүлэх хугацаа болоогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад шашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ХЗДХС-ын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар ХЗДХЯ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,092.0 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	117,339.30	104,420.25	(12,919.05)
Үндсэн хөрөнгө	458,874.84	464,701.91	5,827.07
Нийт хөрөнгө	576,214.14	569,122.17	(7,091.98)
Өр төлбөр	-	-	-

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	576,214.14	569,122.17	(7,091.98)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	576,214.14	569,122.17	(7,091.98)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 104,420.3 мянган төгрөг болж 12,919.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 76,673.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ГИХГ-аас 10,905.8 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан, 100,498.0 мянган төгрөгийн материал зарцуулснаас нь голлон шалтгаалсан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 464,701.9 мянган төгрөг болж, 5,827.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15,097.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, 18,204.1 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, 690,0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, ТӨБЗГ-ын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 232 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан 76,130.8 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийн үнийг шинэчлэн тогтоож, 37,971.7 мянган төгрөгөөр данс бүртгэлд тусгаснаас голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг /улсын төсвөөс/ 729,844.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 704,062.4 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 48,500.0 мянган төгрөг, зэрэг нийт 752,562.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 28,534.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 11,080.0 мянган төгрөг зэрэг нийт 69,739.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,412,666.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор хангамж, бараа материалын зардлыг 10,820.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 15,618.0 мянган төгрөг, зэрэг нийт 33,440.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 103,900.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 19,630.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 9,240.0 мянган төгрөг, зэрэг нийт 132,770.0 мянган төгрөгөөр бууруулсан, зэргээр батлагдсан төсвийг нийт 99,330.0 мянган төгрөгөөр бууруулж, **1,313,336.8** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,313,336.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,313,336.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,108,248.0 мянган төгрөг буюу 84.4 хувьтай тайлагнагдсан нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 203,274.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэгийг 1,814.3 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,270,076.80	1,066,802.32	203,274.48	84.00
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	43,260.00	41,445.71	1,814.29	95.81
	Дүн	1,313,336.80	1,108,248.02	205,088.78	84.38

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130012408 тоот дансанд аймгийн Засаг даргын 2024 оны А/197, А/486 дугаар захирамжуудаар ЗДҮАХХ-ийн зардлаас албан хаагчдын амьдрах байрны засварт нийт 39,306.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс 3,855.0 мянган төгрөгөөр цемент, банз, хайрга худалдан авч, засварын материал, засварын ажлын зардалд 35,451.4 мянган төгрөгийг Сигма-Эс ХХК-д шилжүүлж, албан хаагчдын байрны засварыг хийж гүйцэтгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Шууд худалдан авах босго үнээс давсан 29,800.0 мянган төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагааны гүйцэтгэгийг ГИХГ-т сонгон шалгаруулж, Шунхлай трейдинг ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан “Тээвэр шатахуун нийлүүлэх тухай” ГИХГ/20240102002 дугаартай гэрээний дагуу худалдан авалтыг хийж, төлбөрийг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

ГИХГ-ын Хойд бүс дэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,017,122.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,171.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ХЗДХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 2024 оны 4/1379 дүгээр албан бичгээр ирүүлсэн албан мэдэгдлийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, тус байгууллагад бүртгэлтэй 4 тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар буюу цэнхэр дугаарыг хэрэглэж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ГИХГ-ын Хойд бүс дэх газрын мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллээс 28 төрлийн 182 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” мэдээллийг хугацаа хоцроож мэдээлснийг ГИХГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс илрүүлж, ГИХГ-ын даргын 2024 оны 03 дугаар “Ажлын хариуцлагыг сайжруулах тухай” албан даалгавраар сайжруулахыг үүрэг болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлээгүй, урьдчилж гарсан зардлыг бүртгэж, тайлагнаагүй 2 зөрчилд 6,689.5 мянган төгрөгийн албан шаардлага, “Шийтгэлийн хуудас”-ны тооцоог хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, бараа материалыг буруу бүртгэж, тайлагнасан, хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлээгүй 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	6,689.5	2	6,689.5	100
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	5	6,689.5	5	6,689.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн яамны системээр төсвийн төлөвлөлтийг хийж гүйцэтгэдэг атал ХЗДХС-ын 2022 оны А/128 дугаар тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 3/2881 дүгээр албан бичгийг үндэслэн хөрөнгөнд бүртгэлгүй төсвийн төлөвлөлтийн программын үйлчилгээний төлбөр, хөгжүүлэлтэд 4,000.0 мянган төгрөгийг “Даталанд технологи” ХХК-д шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн “Гадаадын иргэн харьяатын албанд шаардлагатай тоног төхөөрөмж” худалдан авах СЭА01-54/2024 дугаартай гэрээний дагуу 98,156.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг “Арвин дээж” ХХК-аас 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 27/2024 дугаартай комиссын актаар хүлээн авсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй байсан алдааг залрууллаа.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын байцаагчид визийн хураамж 134.8-4,590.0 мянган төгрөгийг тухай бүр бус 6-17 өдрийн дараа төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6 дахь “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Визийн хураамжаар төвлөрүүлсэн бэлэн мөнгөний орлогыг тухай бүр төрийн сангийн харилцах дансанд тушааж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	98,156.0	1	98,156.0			1	98,156.0		
Дүн	1	98,156.0	1	98,156.0			1	98,156.0		

/мянган төгрөгөөр/

Үүнээс

1324100015

9055436

Зөвлөмж

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Визийн хураамжийг ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлээгүй.	1	-					1	-				
Дүн	1	-					1	-				

Үүнээс

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							Тоо Дүн
Дүн							13241/00015 9055436
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн							

